

2018 оны 04 сар 17 өдөр

№ 18/57-01

Улаанбаатар хот

## Солонгос дуу бүжгийн (Kpop&Cover Dance) тэмцээний талаарх удирдамж

Хүлээн авагч тал : .....  
Илгээгч тал : “Ай Эйч Си” ХХК

Танд энэ өдрийн мэндийг хүргье.

Бидний зүгээс жил бүр энэхүү тэмцээнээ уламжлал болгон зохион байгуулж байгаа бөгөөд та бүхэнд тэмцээний удирдамжаа хүргүүлж байгаадаа таатай байна. Манай компани нь БНСУ-ын Инха их сургууль, Ёнсэ их сургууль, Чонжү их сургууль, Аж үйлдвэр техник технологийн их сургууль, Кённам их сургууль, Солонгос олон улсын их сургууль зэрэг олон нэр хүндтэй их сургуулиудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд нийгэмд хандсан ажлын хүрээнд энэ жил 9 дэхь удаагийн Солонгос дуу бүжгийн тэмцээнээ зохион явуулах гэж байна. Энэхүү тэмцээн нь өсвөр үеийн оюутан залууст өөрийгөө хөгжүүлэн Солонгос улсын ёс заншил хэл соёл, /k-pop/ дуу бүжгийн шинэ урсгалд суралцан ихийг таниж мэдэн улмаар үргэлжлүүлэн дэвшин суралцахад нь гүүр болох зорилготой явагддагаараа ихээхэн ач холбогдолтой тэмцээн юм. Жил жилийн тэмцээний ялагчид маань БНСУ-ын их сургуулиудад хэлний бэлтгэлд 100% тэтгэлэгтэй суралцах эрхийнхээ дагуу амжилттай суралцаж улмаар баклавр магистрт дэвшин суралцаж байгаа нь үнэхээр бахархалтай.

Та бүхэн бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна. Тэмцээнийг үзэхэд үнэ төлбөргүй бөгөөд үзэгчдийн дунд азын сугалаа явагдана.

Тэмцээний шагналын сан:

- 1- р байр : Солонгос улсын их сургуульд хэлний бэлтгэлд тэтгэлэгтэй суралцах эрх
- 2- р байр : Зөөврийн компьютер
- 3- р байр : Мөнгөн шагнал
- 4- р байр : Мөнгөн шагнал
- 5- р байр : Мөнгөн шагнал

Тэмцээн болох өдөр : 2018.06.15-ны өдөр 15:00 цагт

Тэмцээн болох газар: Тусгаар тогтнолын ордны 7 давхарын урлаг соёл хурлын зааланд

Бүртгэл болох газар: УБ Зочид буудлын 104 тоот “Ай Эйч Си”ХХК-ны байранд Даваагаас  
Баасан гаригт 09:00 – 18:00 цагын хооронд

Жич: Бүртгүүлхээр ирэхдээ 1% цээж зураг хураамж 10,000₮- ( бэлэг дурсгалын зүйл олгоно.) Солонгост хэлний бэлтгэлд тэтгэлэгтэй суралцах эрх нь сургуулиас тодорхой заагдсан хугацаанд хүчинтэй болно.

Хүндэтгэсэн :

ЗАХИРАЛ: ..... Х.ЯНЖИНСҮРЭН

АЙ ЭЙЧ СИ

ХХК

Хаяг: Монгол Улс Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг 8-р хороо,  
Улаанбаатар зочид буудлын 104 тоот.

Утас: 70117000, 99133937  
вэб сайт: [www.ihcmongolia.com](http://www.ihcmongolia.com)